

БАТЛАВ  
МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА А.НАРАНТУЯА



Сургалтын комиссын 2024 оны 05 дугаар сарын  
07-ны өдрийн хурлаар хэлэлцэж, зөвшөөрөв.

## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо: 2024.05.07.

Мал эмнэлгийн ерөнхий газраас ХХААХУ-ийн сайдын 2020 оны А/385 дугаар тушаалаар батлагдсан “Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журам”-ын 2.4.2. дахь заалтыг үндэслэн малын эмч, мэргэжилтнүүдэд зориулсан багц цагийн сургалт зохион байгуулах байгууллагын сонгон шалгаруулалт зарлаж байна.

Сургалт зохион байгуулах байгууллага нь дараах 8 үндсэн чиглэлээс сонгож, сургалтын хэрэгцээ тогтоох судалгаа хийж, өөрийн сонгосон сэдвийн хүрээнд хөтөлбөр боловсруулж ирүүлнэ.

### Сонгон шалгаруулалтын нэр:

Малын эмч, мэргэжилтнүүдэд зориулсан  
багц цагийн сургалт зохион байгуулах  
байгууллагын сонгон шалгаруулалт

### Сонгон шалгаруулалтын дугаар: СЭБСШ – 02/2024

Сургалт зохион байгуулах байгууллага нь Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/217 тушаалаар баталсан сургалтын хөтөлбөрийн үлгэрчилсэн загварын дагуу сургалтын иж бүрэн модуль боловсруулах, тус модулийг ашиглан сургалт зохион байгуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

### Сургалтын үндсэн чиглэл 1: Мал эмнэлгийн хууль, эрх зүй, мал эмнэлгийн бизнес менежмент

Хөтөлбөр №1: .....

Хөтөлбөр №2: .....

### Сургалтын үндсэн чиглэл 2: Мал эмнэлгийн эм зүй, эмийн сан

Хөтөлбөр №1: .....

Хөтөлбөр №2: .....

### Сургалтын үндсэн чиглэл 3: Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчин

Хөтөлбөр №1: .....

Хөтөлбөр №2: .....

### Сургалтын үндсэн чиглэл 4: Хүнсний аюулгүй байдал, нийтийн эрүүл мэнд,

Хөтөлбөр №1: .....

Хөтөлбөр №2: .....

### Сургалтын үндсэн чиглэл 5: Мал, амьтны халдваргүй өвчин

Хөтөлбөр №1: .....

Хөтөлбөр №2: .....

### Сургалтын үндсэн чиглэл 6: Эрчимжсэн аж ахуй, төрөлжсөн мал эмнэлэг

Хөтөлбөр №1: .....

Хөтөлбөр №2: .....

### Сургалтын үндсэн чиглэл 7: Тархвар зүй, мэдээллийн сан

Хөтөлбөр №1: .....

Хөтөлбөр №2: .....

## Сургалтын үндсэн чиглэл 8: Мал эмнэлгийн лаборатори

Хөтөлбөр №1: .....

Хөтөлбөр №2: .....

Сургалтын зохион байгуулах байгууллага нь нэг буюу түүнээс дээш хөтөлбөрт санал ирүүлж болно.

### Сургалт зохион байгуулах байгууллагад тавигдах шаардлага:

Сургалт зохион байгуулах байгууллага нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/385 дугаар тушаалаар батлагдсан “Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журам”-ын 3.1, 3.3, 3.4-д заасан шаардлагыг тус тус хангасан байна.

№	Тавигдах шаардлага	Нотлох баримт
1	Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ албан ёсоор илэрхийлсэн байх	<ul style="list-style-type: none"><li>Байгууллагын удирдлагын албан бичиг</li></ul>
2	Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд нийцэж байх	<ul style="list-style-type: none"><li>Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /Гэрчилгээнд сургалт, судалгаа явуулахаар бүртгэгдсэн байх/</li><li>Үйл ажиллагааны товч танилцуулга</li></ul>
3	Сургалт хийж байсан туршлага бүхий багштай байх	<ul style="list-style-type: none"><li>Сургалтын сэдэв, огноо, зорилтот бүлэг, багш нарын нэр болон сургалтын асуудал хариуцах хүний холбоо барих мэдээллийг багтаасан жагсаалт</li><li>Өмнөх хугацаанд зохион байгуулсан 2-3 сургалтын товч танилцуулга /гэрэл зураг оруулсан бол зураг тус бүр тайлбартай байна /</li><li>Сүүлийн 2 жилд зохион байгуулсан сургалтын жагсаалт /Сургалтын нэр, огноо, үргэлжилсэн хугацаа, байршил, оролцогчийн тоо, сургалтын асуудал хариуцах хүний холбоо барих мэдээлэл/</li></ul>
4	Шаардлага хангасан сургалтын анги танхимтай байх	<ul style="list-style-type: none"><li>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, эсхүл түрээсийн гэрээний хуулбар</li><li>Сургалт хийх болон дадлагын танхим сургалтад ашиглах хэрэгсэл багтаасан /ширээ, сандал, самбар, компьютер, дэлгэц, проектор болон бусад багаж, тоног төхөөрөмж г.м/ бүрэн харуулсан 6-аас доошгүй ширхэг гэрэл зураг;</li></ul>
5	Сонгосон хөтөлбөрөөр сургалт зохион байгуулахад шаардлагатай хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэлтэй байх	<ul style="list-style-type: none"><li>Сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийн нэр, зориулалт, хүчин чадлыг тодорхойлсон жагсаалт</li><li>Техник хэрэгсэл тус бүрийн гэрэл зураг</li></ul>
6	Сонгосон хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах мэргэшсэн баг бүрдүүлсэн байх	<ul style="list-style-type: none"><li>Үндсэн болон гэрээгээр ажиллах багшийн А4 хэмжээний нэг хуудаст багтаасан товч танилцуулга (CV);</li><li>Багш тус бүрийн хөдөлмөрийн гэрээ, эсхүл хөлсөөр ажиллах гэрээний хуулбар</li></ul>

Сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллагуудад тухайн хөтөлбөрөөр сургалтын модуль боловсруулах, сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд Дэлхийн банкны Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслөөс техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах тул сургалтын модуль (Багшийн гарын авлага – сэдвийн агуулга, заах арга зүйг багтаасан нарийвчилсан хөтөлбөр, хэвлэмэл үзүүлэн, видео контент, шаардлагатай хэрэглэгдэхүүний танилцуулга, тестийн сан болон Оролцогчид зориулсан тараах материал-бичвэр, нугалбар, товхимол гэх мэт)

боловсруулахад шаардагдах төсөв болон сургалт зохион байгуулах зардлыг хөтөлбөр тус бүрээр нарийвчлан боловсруулж ирүүлсэн байх шаардлагатай.

Сонгон шалгаруулалтад оролцох сонирхолтой байгууллагуудад зориулсан САНАЛ ИРҮҮЛЭХИЙН ӨМНӨХ УУЛЗАЛТ-ыг **2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 14:00 цагт** Мал эмнэлгийн ерөнхий газрын 27 тоот өрөөнд зохион байгуулна.

**Санал хүлээн авах эцсийн хугацаа: 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 10 цаг 00 минут хүртэл.** Сонгон шалгаруулалтад оролцох сонирхолтой байгууллага /Хуулийн этгээд/ нь дээрх шаардлагыг хангаж байгааг нотлох баримтыг бүрдүүлж ирүүлэх ба заасан хугацаанаас хоцорсон саналыг хүлээн авахгүй.

Санал ирүүлж байгаа байгууллага сургалтын хөтөлбөрийн агуулга, эзэмшүүлэх мэдлэг, чадварын хүрээг баримтлан дараах мэдээллийг нэмэлтээр оруулж, саналд хавсарган ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын нэр;
- Сургагч багш нарын мэдээлэл;
- Сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөө;
- Мэдлэг шалгах сорилын тест;

Санал бэлтгэх хугацаанд лавлах, тодруулга авах шаардлагатай тохиолдолд [trainingcommission@vet.gov.mn](mailto:trainingcommission@vet.gov.mn) хаягаар болон утас 51-262482 (Өрөөний дугаар-29)-аар холбогдоно уу.

**Санал ирүүлэх хаяг, хүлээн авах албан тушаалтан:**

Мал эмнэлгийн ерөнхий газарт албан бичгээр ирүүлэхийн зэрэгцээгээр цахим хувилбарыг дээрх хугацаанд ирүүлнэ.

**Хэвлэмэл хувийг:** Мал эмнэлгийн ерөнхий газрын Бичиг хэргийн ажилтан (Өрөөний дугаар-32 тоот:, Утас: 267633).

**Цахим хувийг:** [trainingcommission@vet.gov.mn](mailto:trainingcommission@vet.gov.mn) хаягаар ирүүлэх.

Энэхүү сонгон шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн хөтөлбөрийг хянан магадлах, үнэлэх ажлыг Мал эмнэлгийн ерөнхий газрын Сургалтын комисс гүйцэтгэнэ.

Үнэлгээний үр дүнгийн талаарх мэдэгдлийг санал хүлээн авсан өдрөөс хоёр долоо хоногт багтаан бүх оролцогчдод хүргүүлнэ.

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР